



## ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/Н17

Арвайхээр

### Тендерийн гүйцэтгэгчийг сонгох, тендер хүчингүй болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 30 дугаар зүйлийн 30.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 64 дүгээр дүгнэлтийн дагуу Төрийн байгууллагуудын завсар, тоног төхөөрөмж /Өвөрхангай/ ажлын 4 дүгээр багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Бүрд сум/ ажлыг 68450000 (жаран найман сая дөрвөн зуун тавин мянга) төгрөгөөр Богдын буян ХХК-иар, 6 дугаар багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Баян-Өндөр сум/ ажлыг 44980642 (дөчин дөрвөн сая есөн зуун наян мянга зургаан зуун дөчин хоёр) төгрөгөөр Дуутын нуруу ХХК-иар, 7 дугаар багц Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын компьютер, тоног төхөөрөмж /Өвөрхангай 12 сум/ ажлыг 38880000 (гучин найман сая найман зуун наян мянга), 8 дугаар багц Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газрын тавилга хэрэгсэл /Өвөрхангай 12 сум/-д 42900000 (дөчин хоёр сая есөн зуун мянга) төгрөгөөр тус тус Их-Угалз ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан), аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Ч.Гүнсэнхорол) нарт даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д үүрэг болгосугай.

4. Шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй 1 дүгээр багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Гучин-Ус сум/, 2 дугаар багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Өлзийт сум/, 3 дугаар багц Засаг даргын Тамгын газрын барилгын их засвар /Өвөрхангай, Баруунбаян-Улаан сум/, 5 дугаар багц Багийн төвийн барилгын их засвар /Өвөрхангай, Хайрхандулаан сум 5 дугаар баг/ ажлуудыг хүчингүй болгосугай.

5. Дээрх хүчингүй болсон багцуудыг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар дахин зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100692